

## 9

## ХУВЬЧЛАЛЫН МӨН ЧАНАР

## Н.Ганбямба

Хувьчлал нь дэлхийн эдийн засагт сүүлийн жилүүдэд хүчтэй түрэн орж ирсэн томоохон үйл явдлын нэг болж байна.

Өмч хувьчлалын үйл явцын тодорхой зурваст өвөрмөц онцлог илэрч байгаа бөгөөд түүний нэгэн жишээ бол социалист харилцаанаас зах зээлийн харилцаат эдийн засагт шилжиж буй орнуудад хийгдэж байгаа өргөн хүрээ бүхий хувьчлал юм. 1990-ээд оноос социалист тогтолцоо задран төрийн өмч хувьчлал социалист харилцаатай гуч орчим улсыг хамарсан.

Хувьчлалын үйл явцад БНХАУ, Вьетнам болон бусад орон зүй ёсоор хамрагдана.

Зах зээлийн харилцаа төлөвшсөн орнууд хөрөнгө нөөцийн, үйлдвэрлэлийн, хуваарилалтын үр ашгийг нэмэгдүүлэх нь хувьчлалын гол зорилго гэж үздэг байна.

Харин хөгжлийн түвшингээр доогуур орнуудын хувьд хувьчлалаар дамжуулан зах зээлийг өргөжүүлэх, үйлдвэрлэл эрхлэх сонирхолыг нэмэгдүүлэх, хувь хүмүүсийн чөлөөт байдлыг хангах, төсөвт орлого оруулах, улсын санхүү банкны тогтолцоог эрүүлжүүлэх, эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, үйлдвэрлэлийн өрсөлдөөнийг идэвхжүүлэх, удирдлагын механизмыг хөгжүүлэх болон эдийн засгийн бус зорилтыг шийдэж байгаа.

Хувьчлалын тодорхой зорилго, үр дүнгийн логик уялдааг зөв хангах нь хувьчлалын менежментийн онол арга зүйн чухал асуудал болно.

Шилжилтийн орнуудын хувьд хувьчлалын зорилго нь эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхийн хамт бусад олон зорилтыг давхар шийдэх бөгөөд хувьчлах **цогцолбор зорилт** дэвшүүлэх хэрэгтэй болдог.

Зах зээлийн харилцаат эдийн засагт шилжиж байгаа шилжилтийн орны хувьчлалын явцыг дүгнэж үзвэл:

1. Зах зээлийн харилцаат эдийн засагт шилжихийн тулд хувьчлалыг өргөн хүрээнд хийх нь бодит хэрэгцээ байжээ. Үүний үр дүнд өмчлөлийн харилцаанд зарчмын өөрчлөлт орууллаа.
2. Хувьчлалын анхаарлын төвд байсан ба байх ёстой гол асуудал:
  - Хувьчлалын ямар арга хэрэглэх
  - Ямар зарчим баримтлах
  - Ямар хөтөлбөрөөр хувьчлах
  - Хувьчлах эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын болон бусад ямар урьдчилсан нөхцөл орчин бүрдүүлэх
  - Хувьчлах бэлтгэл ямар ажлууд амжуулсан байх
  - Ямар үр дүнд хүрэх
  - Хувьчлалын явцад эерэг сөрөг ямар үйлдэл гарч болох, түүнийг давах урьдчилсан арга хэмжээ юу байх гэх мэт
3. Анхаарал татаж байгаа асуудал:
  - Өмчлөлийн бүтцийг өөрчлөх, зохицуулах (Орос),
  - Гадаад стратеги
  - Хөрөнгө оруулагчдад чөлөөтэй хувьчлах
  - Төрийн өмчид үлдэж байгаа аж ахуйн нэгжүүдэд онцгой анхаарах (менежмент, үр ашиг)
  - Социалист зах зээлийн хэрэгцээ хангах зориулалттай том масштаб бүхий үйлдвэрүүдийг хувьчлаагүй байх (Гүрж)
  - Төрийн өмчид стратеги ач холбогдолтой зарим компаниудыг монополиястатустай үлдээх (Румын)
  - Тухайн улсын тухайн бодит салбарын онцлогийг харгалзах (бэлчээрийн мал аж ахуй гэх мэт)

Өмч хувьчлал нь нийгмийн, эдийн засгийн, улс төрийн, хууль эрх зүйн, нийт хүн амын ахуй амьдралын, улс орны нийтлэг хөгжлийн, тусгаар тогтнол аюулгүй байдлын болон бусад гол гол асуудал, үйл ажиллагааг хамардаг үр дагавар нь үргэлжлэн илэрч, нөлөөлдөг зангилаа чухал асуудал мөн. Иймд өмч хувьчлалтай холбогдон олон цогцолбор асуудал зэрэг хөндөгдөн тавигдана.

Хувьчлал бол улс төр, эдийн засгийн шинэчлэлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэсэн дүгнэлт хийж, зах зээлийн харилцаат эдийн засгийн тогтолцоонд шилжихийн тулд төрийн өмчийн хувьчлалыг эрчимтэй хийх ёстой гэсэн үзэл баримтлал шилжилтийн дийлэнх оронд давамгайлсан. Үнэндээ шилжилтийн орон бүрд өмч хувьчлалын үйл явц эхлэхийн өмнө өмч хувьчлалын онол арга зүйн асуудлаа бүрэн цэгцтэй шийдэгдэж чадаагүйг хүлээн зөвшөөрөх ёстой. Социалист орнуудын эдийн засгийн харилцаанд том өөрчлөлт хийх шаардлага 80-аад оны эхний хагасаас бодитой болж өөрчлөлт шинэчлэлт нэлээд орнууд хийсэн боловч зарчмын үр дүнд хүрч чадаагүй байлаа. Гэтэл 90-ээд оны эхээр гадаад, дотоодын тодорхой хүчин зүйлээс болж социалист харилцаа задарсан нь бидний өнөөгийн мэдлэгийн түвшинд зөв гэж ойлгогдож байгаа зах зээлийн харилцаат эдийн засагт эдгээр орнууд шилжин орохоос өөр аргагүйд хүрсэн.

Өмчлөлийн онол арга зүйн асуудал өмч анх үүсэн бий болсон үеэс эхэлсэн урт түүхтэй бөгөөд үргэлж шинэ асуудал гарч байдгийн дээр эцэслэн бүрэн шийдэж чадалгүй өнөөг хүрсэн чухал, хэцүү асуудал ч олон бий.

Өмч хувьчлалын онол арга зүй 1960-аад оны сүүлчээр нийгмийн захиалга болон гарч ирсэн бөгөөд хувьчлалыг онолын үндэслэлтэй бодлого, арга замаар хангах хэрэгцээ 90-ээд оны

эхэн үед улам ч нэмэгдсэн. Үүнтэй холбогдон өмч хувьчлах шаардлага, хувьчлалын зорилго, хэрэгжүүлэх арга хэлбэр, хувьчлалын үр дүнгийн хэмжүүр, шилжилтийн үеийн хувьчлалын онцлог, түүний хэрэгжих хугацаа, механизм зэрэг олон асуудалд онолын үндэслэл хэрэгтэй боллоо. Үүний хүрээнд нийгмийн хөгжил, эдийн засаг, улс төр, хүн амын ахуй амьдрал зэрэг нийгэм-эдийн засгийн том том бүлэг шинжлэх ухааны асуудлууд дэвшигдэн тавигдсан ба эдгээрийг нэгтгэн хэрхэн шийдэх нь өмч хувьчлалын эцсийн үр дүнд шууд нөлөө үзүүлэх байв.

Хувьчлалын онол нь шинжлэх ухааны шаардлагат түвшинд тэр бүр хүрээгүй, нийгмийн хэрэгцээт олон талаар хангаж чадахгүй байгаа ба хувьчлалын шинэ шинэ асуудлууд тэр бүр онол арга зүйн үндэслэлтэй шийдэгдэж чадахгүй байна.

Шилжилтийн орнуудад хувьчлал хийх онолын суурь асуудал нь төрийн өмчийг хувьд шилжүүлэх явдал болж байна. Түүний үндсэн шалтгаан нь улсын үйлдвэрийн газрууд үр ашиг муутай, зах зээлийн харилцаат эдийн засагт хувийн өмч шийдвэрлэх нөлөөтэй гэж тайлбарлаж байна. Үүнтэй уялдан олон асуудал гарч байгаа ба эдгээрийн нэг нь төрийн ба хувийн өмчийн давуу сул тал, эдийн засгийн амьдралд төрийн гүйцэтгэх үүрэг юм.

Аливаа эдийн засгийн юмс үзэгдэл, бодлогыг үнэлж дүгнэх онолын шалгуур үзүүлэлт бол төгс өрсөлдөөнт зах зээл гэсэн арга зүйн үндэслэлийг ч зах зээлд ороогүй байгаа буюу тэрхүү төгс хөгжсөн зах зээлийн харилцааны түвшинд хүрээгүй орнуудад хүчлэн хэрэглэх оролдлого ч гарч байлаа.

Өөрийн ашиг сонирхлоо хөөсөн хувь хүмүүс “нийгмийн ашиг тус” авчирдаг, харин нийгмийн төлөө гэж хоосон уриалсан бүхэн тэгж чаддаггүй гэсэн хатуу дүгнэлтийг Адам Смитийг барин хийж, зах зээлийн харилцааны үеийн бүтэлгүйтлийг засахын тулд төрийн эдийн засгийн оролцоог шаарддаг боллоо.

*Энэ бүгд нь асуудалд зөвхөн нэг талаас хандсан “хувийн хэвшлийг хөгжүүлэхийг” хүчлэн оролдсон алхмууд бөгөөд улс бүрд, хөгжлийн тодорхой нөхцөл байдалд заавал тохирох албагүй онол арга зүйн үндэслэл гэж үзэж байна.*

Хувьчлал нь улс төрийн шинж чанартай болон хувирдаг, ялангуяа шилжилтийн орнууд бүр ч их улс төржсөн, хэцүү асуудал болдог нь өнгөрсөн арав гаруй жилийн үйл явцаас харагдаж байна.

Улс орны эдийн засгийн хөгжлийн байдал төдийгүй, хамрах салбар, тухайлсан объектын шинж байдалтай нийцсэн онол арга зүйн үндсэн дээр хувьчлах шаардлагатай байна.

Хувьчлах, ялангуяа шилжилтийн орнуудад хувьчлал хийхийн тулд эхлээд хувьчлах онол арга зүйн бат үндэслэл боловсруулах хэрэгтэй. Учир нь шилжилтийн орнуудад хувьчлал хийх нь хамрах хүрээ, үр дагавараар хувьчлалын ерийн үйл ажиллагаанаас хавьгүй их нөлөөтэй эдийн засаг улс төрийн ажил бөгөөд үр дүн нь эдийн засгийн нийт хөгжил, үр ашиг, нэгэнт бий болгосон улсын нийт баялагийн ашиглалт өмчлөлтэй шууд холбогдож байгаад оршино. Хувьчлалын онолын асуудлаас энд заримыг хөндөн өгүүлье.

**Нэг. “Өмч эдийн засгийн үндэс суурь болох тухай” онолыг шүүмжлэх нь**

Энэхүү онол нь нийгмийн байгуулал, нийгмийн харилцааг өөрчлөх, шинэ харилцааг төлөвшүүлэн тогтоохын тулд өмчийн хэлбэрийг өөрчлөх бодлого, арга хэмжээтэй шууд

холбогдон гарч ирсэн түүхтэй. Социалист өмч нийгэм эдийн засгийн бат бааз болох тухай социалист орнуудын, ялангуяа ЗХУ, манай нам төрийн гол гол баримт бичиг, эрдэмтдийн бүтээлд олонтаа өгүүлж байсан.

Бүх өмчийг "улсын" өмчийн хэлбэрт оруулж, шинээр бий болгох өмч нь зөвхөн улсынх байхаар төр хүчлэн зохион байгуулж байлаа. Түүгээр ч үл барам 100% улсын өмч болох нь үндсэндээ социализмын бүрэн ялалтыг хангах хэмжүүр хэмээн үзэж байсан эрдэмтэд ч байсан.

Ийнхүү юуны түрүүн өмчийг шууд хүчлэн 100% улсынх болгох нь нэг талаас тухайн үеийн улс төрийн эрх ашигт нийцүүлсэн гэгдэх боловч, нөгөө талаас өмчлөлийн харилцааг бодитой хэрэгжүүлэх эдийн засгийн бааз суурь байгаа эсэхэд бага анхаарсан хэрэг байв.

Энэ байдалтай холбогдуулан "өмч эдийн засгийн үндэс суурь мөн" гэсэн онол номлолтой санаа зөрдөг эрдэмтэн Монгол улсад байсан ба байгаа юм.

Аль нэгэн хэлбэрийн өмч ноёрхон тухайн улсын эдийн засгийн үндэс суурь болох тухай онол нь нийгмийн байгуулал, нийгмийн харилцааг өөрчлөх, шинэ харилцааг төлөвлүүлэн тогтоох зорилгоор өмчийн хэлбэрийг өөрчлөх бодлого, арга хэмжээтэй шууд холбогдон гарч ирдэг.

Тухайн хэлбэрийн өмч дангаар ноёрхон тухайн улсын нийгэм, эдийн засгийн бат бааз болох нь улс төрийн бодлого, эдийн засаг, нийгмийн үндсэн асуудал болон үйлдвэрлэх хүчинт үйлдвэрлэлийн харилцааны диалектикийг зөрчсөн буруу онол бөгөөд энэ нь дээр дурдсан онолын алдаа, түүнийг социалист байгуулалтын бүтэлгүйтлээр нотлож байна.

Социалист байгууламжийн сургамжаас дүгнэхэд социализм байгуулах тухай хувийн өмчийг улсын болгох бага хэрэг, харин нийгмийн үйлдвэрлэлийг хэрэг дээрээ нийгэмчлэх, тухайлбал эдийн засгийг зохих түвшинд хүртэл хөгжүүлэх явдал чухал. Тухайн нийгмийн эдийн засгийн үндэс суурь тавьсан эсэхийг үйлдвэрлэх хүчний хөгжлийн хүрсэн түвшингээр тодорхойлж болно. Үйлдвэрлэх хүчний нийтлэг хөгжлийн зүй тогтлын үүднээс авч үзвэл ямар ч улс өөрийн хүчээр нийгмийн өргөтгөсөн нөөц үйлдвэрлэлийг үр ашигтай, тасралтгүй явуулж байвал эдийн засгийн үндэс суурьтай болсон хэрэг мөн.

**Нэгдүгээрт**, Тухайн улсад нэгэнт бүрэлдэн бий болсон үйлдвэрлэлийн хэрэгслийг цөмийг нь социалист өмчинд хамруулсан ч гэсэн үйлдвэрлэх хүчний хөгжил социализмын эдийн засгийн бааз суурь тавих түвшин хэмжээнээс хоцорсон бол социалист өмч нийгмийн эдийн засгийн бат бааз болж чадахгүй нь түүхээр батлагдаад байна.

**Хоёрдугаарт**, Өмчлөлийн харилцаа нь бодит эдийн засгийн түвшинд нийцэн бүрэлдэн төлөвшиж үйлчилдэг гэдгийг түүх бас баталж байна.

**Алив улсын эдийн засгийн бодит үндэс суурь нь өмчийн хэлбэр, түүний өөрчлөлтөөр илэрхийлэгдэх бус бодит эдийн засгийн нөхцөл байдалд нийцсэн өмчийн хэлбэрүүд бүрэлдэн тогтох ёстой.** Тэдгээр өмчийн хэлбэрүүд нь эргэж эдийн засгийн хөгжилд хүчтэй бодитой, эерэг нөлөө үзүүлэх ба эдийн засгийн харилцааг зохицуулах арга механизмыг ашиглах төрийн хүчтэй зэвсэг болж өгнө.

Эдийн засгийн үндэс суурьт бүрэн нийцээгүй өмчийн хэлбэр, тогтолцоо нь зөвхөн улс төрийн эрх ашигтай шууд холбоотой болохоос бус нийгмийн, тэр тусмаа эдийн засгийн үндэс суурь болдоггүй.

Социалист харицаанаас зах зээлийн харилцаанд шилжин орох үед ч гэсэн дээр дурдсан

онолын үндэслэл зайлшгүй мөрдөгдөх ёстой ба эдийн засгийн бааз суурь, хөгжлийн түвшин, бүтэц, хэмжээ, онцлогийг бүрнээ харгалзан үзэлгүйгээр өмчийг хүчлэн дур зоргоор нэг хэлбэрээс нөгөөд 100% шилжүүлэх нь өмчлөлийн зөв тогтолцоо бүрдүүлэх, төлөвшүүлэхэд том алдаа гаргах, улмаар эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлөх муу талтай, буруу бодлого болдог. Иймд Монгол улс шилжилтийн энэ эмзэг чухал үед өмнө нэгэнт гаргасан алдааг давтах ёсгүй, үүнээс сэрэмжлэх ёстой. Өмчийн аль нэгэн хэлбэр эдийн засгийн үндэс суурь болно гэсэн онолын үндэслэл, түүнээс улбаалан гарсан бусад үзэл, онол, хандлагаас зайлсхийх, алдааг давтан гаргахгүй байхад хэргийн учир бий. Ялангуяа, онолын энэ алдааг өмч хувьчлалын бодлогод, хувьчлалын үйл явцад онцгой анхааран үзвэл зохино.

Өмч хувьчлахад улс төрийн эрх ашиг, ашиг хонжоог тухайн үеийн засгийн эрх барьж байгаа засгийн газар, нам эвсэл, бусад хүчнүүд хардаг ба үүний дагуу ч хувьчлал хийж эдийн засгийн үр ашиг, эдийн засгийн хөгжил, нийгмийн нэгэнт бүрэлдэн бий болгосон баялагт их хэмжээний хохирол учруулж болох юм. Магадгүй ийм атгаг явдлыг ард түмнээс булахын тулд өмч хувьчлалд олсон гол үр дүн нь "улс төрийн үр дүн", "өмч хувьчлалын үр ашиг, тухайлбал эдийн засгийн үр ашиг улс төрийн үр ашгаас хожуу гарна" гэх буюу "хувьчлалын эдийн засгийн, ер нь үр ашиг гарах цаг нь болоогүй" гэсэн номлол гаргаж болох юм.

#### Хоёр. Өмчийн хэлбэрийг өөрчлөх нь өмчлөлийн харилцааг зохисжуулахын тулд болой

Эдийн засгийн хөгжлийн хүрсэн түвшин, эдийн засгийн хэмжээ бүтэц, онцлогт тухайн улсын эдийн засагт үйлчлэх эдийн засгийн харилцаа бүрэн зохицсон байх зүй тогтолтой. Энэ бол эдийн засгийн онолын нийтлэг, нэгэнт батлагдсан нийтээр хүлээн зөвшөөрдөг, дэлхийн эдийн засгийн практикт хэрэгжиж байдаг үндэслэл мөн. Улс орон төдийгүй, аж ахуйн нэгж, өрх, иргэн бүрийн амьдрал ахуй, үйл ажиллагаанд хэрэгжих ёстой энэхүү нийтлэг хууль, зүй тогтолыг өмч хувьчлалын үйл явцад зайлшгүй дагаж хэрэгжүүлэх ёстой.

Төрийн өмчийг хувьчлахын тулд хувьчилж байгаа бус, нийгмийн байгууллын мөн чанар, тухайн орны эдийн засгийн байдалд бүрнээ нийцүүлэн эдийн засгийн харилцааны тогтолцоог бүрдүүлж, үйлдвэрлэх хүчин үйлдвэрлэлийн харилцааны нэгдэл, зохицолдоог хангах, улмаар эдийн засгийн харилцааны механизмыг эдийн засгийг хөгжүүлэх, нийгмийн зорилтыг шийдвэрлэхэд ашиглах болон үйлдвэрлэлийн харилцаатай холбогдон гаргах бусад олон асуудлыг оновчтой шийдэхэд үйлдвэрлэлийн харилцааг бүхэлд нь чиглүүлэхэд өмчлөлийн харилцааг зохистой бүрдүүлэх, ашиглах зорилгоор хувьчлал хийж байгаа билээ. Ийм учраас хувьчлалын чиглэл, зорилтыг өмчийн хэлбэр өөрчлөх, хувийн өмчийг хамгийн чухалд үзэн түүний эдийн засагт эзлэх хувь хэмжээг хэтрүүлэх гэх мэтийн өнгөц байдлаар хандаж огт болохгүй гэдгийг онцлон анхаарах хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, хувьчлалын дүнд, хувийн өмчийн эзлэх хувь хэмжээг хамгийн нийцтэй хэмжээнд хүргэх зорилт тавих ёстой.

Эдийн засгийн харилцааны тогтолцоонд өмчлөлийн харилцаа гол байр эзэлдэг бөгөөд өмчлөлийн харилцааг зөв бүрдүүлэх, төлөвшүүлэхэд өмч хувьчлалыг ашиглахдаа өмчийн хэлбэрүүдийн хоорондын харьцааг эдийн засгийн бодит үндэс суурьт бүрнээ нийцүүлэн шийдэх явдал гол тулгуур болно гэсэн онолын үндэслэл дэвшүүлж байна. Үүнд тулгуурлан төрийн өмчийг хувьчлах буюу цаашид өмчийн харилцаанд өмчийн хэлбэрийг зохисжуулах шаардлагатай.

Өмч хувьчлал нь дан ганц төрийн өмчийг хувьчлах үйл явцаар хязгаарлагдахгүй. Орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлэх, өмчийн бусад хэлбэрүүдийн хооронд өмч шилжүүлж хувьчлал хийгдэхээс гадна төр нь өмчийн бусад хэлбэрээс өөртөө өмч хувьчлах замаар өмчтэй болох явдал байж болно. Магадгүй төрийн өмчийн хувьчлал хэтэрсэн тохиолдолд

буюу бусад шаардлагатай тохиолдолд хувьчлалыг олон хэлбэрээр хийж, өмчлөлийн харилцааны зөв тогтолцоо бүрдүүлж, төлөвшүүлэхэд хувьчлалыг ажиллах хэрэгцээ цаашид гарахыг үгүйсгэх юун. Харин өмч хувьчлал ийнхүү өргөжин явагдахад төр гол үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна.

Өмч хувьчлалын асуудалд өмчийн хэлбэрийн талаас өнгөц хандах нь алдаанд хүргэдэг бөгөөд тухайн улсын бодит эдийн засгийн хөгжлийн түвшинтэй нийцэж байх онолын үндэслэлийг анхаарч үзвэл зохионо гэдгийг дахин хэлмээр байна.

**Зах зээлийн харилцаат эдийн засагт шилжих нь өнөөгийн дэлхийн хөгжлийн нөхцөл байдал, шаардлагад нийцэж байгаа ба манай улс уул харилцаанд шилжих шилжилт хийж байна. Монгол орон өндөр хөгжсөн зах зээлийн харилцаанд ороогүй, орох ч боломжгүй, тийм зорилт ч дэвшүүлээгүй байна. Харин Монгол улс зах зээлийн харилцаат эдийн засгийн хөгжлийн анхны шатанд буюу зах зээлийн харилцааны хөгжлийн доод шатанд явж байна. Ийм байхад чөлөөт өрсөлдөөнт зах зээлийн харилцааны нөхцөлд хэрэгждэг зүй тогтол, зарчим, шаардлага, механизмыг хүчээр хуулбарлан Монголд хэрэглэх оролдлого хийх нь онолын хувьд буруу, хэрэгжих нөхцөл бололцоогүй, сохроор бусдыг даган дуурайсан бүдүүлэг алдаа болно. Үүнээс болж улс орон их хэмжээний хохиролд орж болох юм. Иймд зах зээлийн харилцааг бүрдүүлэн тогтоохдоо улсын хөгжлийн хүрсэн түвшин, онцлогт нийцсэн эдийн засгийн ба өмчлөлийн загвар сонгон авч, түүнийг шатлан хэрэгжүүлэх, төлөвшүүлэх явдал чухал.**

Манай зарим хүмүүсийн сэтгэлгээнд байдаг нэгэн хандлага бол зах зээлийн харилцаат эдийн засагт шилжих нь асуудлыг нийцтэй шийдэх бүх боломж бүрдэх мэтээр гэнэн бодох, энэ харилцаа нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн бүх асуудлыг ямар ч бэрхшээл саадгүйгээр шийдэх мэтээр буруу ойлгож, зах зээл бол "диваажин" мэтээр бодох, сэтгэх явдал юм.

Зах зээлийн харилцаа бол хамгийн хүчтэй өрсөлдөөн, тэмцэл мөн. Энэ тэмцэл, өрсөлдөөнд хүчтэй нь хүчгүйгээ, сайн нь сайнаа ялан дийлэх жамтай. Зах зээлийн харилцааны жам, зүй тогтол одоо нэгэн орны хүрээнээс хэдийнээ гарч нийтээр үйлчилж байгааг хөгжлийн түвшингээр доогуур, жижиг буурай, бас зах зээлийн харилцаа руу шинээр орж яваа орон онцгой анхаарах учиртай. Энэ тэмцэл, өрсөлдөөнд хэрхэн оршин тогтнох, өмчлөлийн харилцааны хүрээнд баримтлах өөрийн онол, өөрийн бодлого, өөрийн арга замтай байх хэрэгтэй.

**Тухайн улс дахь өмчлөлийн харилцаа нь зах зээлийн эдийн засгийн харилцааны гол цөм болохын дээр тухайн орны эдийн засгийн байдалд шууд зохицон тогтоно. Өмчлөлийн харилцааны тогтолцоог бүрэлдүүлэх, төлөвшүүлэх, ашиглах төрийн бодлого боловсруулах явдал чухал байна.**

Асуудалд өмчийн хэлбэр талаас бус өмчлөлийн агуулгаас анхааран хандая.

**Гурав. Өмчлөлийн харилцааг нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд ашиглах нь**

Тухайн байгууллын зүй тогтол, зарчмыг амьдралд хэрэгжүүлэхийн тулд өмчлөлийн харилцааг ашиглах зайлшгүй хэрэгцээ гардаг. Харин өмчлөлийн харилцааны механизмыг ашиглах нь тухайн орны тухайн нөхцөл байдал, зорилгоос шууд хамаарна.

Иймд манай улсын одоогийн нөхцөл байдал, хөгжлийн хэтийн төлөвөөс өмчлөлийн харилцааг эдийн засгийг хөгжүүлэх хүчтэй механизм болгон ашиглах талаас өмч хувьчлал, шинэ хэлбэрийн өмчийн бүрдэлт, тухайн өмчийн гүйцэтгэх үүргийг зөв тодорхойлох, дэмжих,

ашиглах ёстой гэж үзнэ. Тодруулбал өмчийн ямар хэлбэр, ямар үүрэг гүйцэтгэх, ямар үр дүнд хүргэх ёстой, түүний дагуу өмчийн хэлбэрийн бүрдэлт, ашиглалтын хүрээнд ямар бодлого хэрэгжүүлэхийг төр шийдэх учиртай.

Манай улсын хөгжлийн өнөөгийн байдал, нийгмийн харилцааны шилжилт, эдийн засгийн өвөрмөц онцлог зэрэгтэй уялдуулан тухайн хэлбэрийн өмч эдийн засаг, нийгэм, улс төр ба нийгмийн амьдралын бусад хүрээнд ямар ямар үүрэг гүйцэтгэх ёстойг тодорхойлох, хэрэгжүүлэх нь эдийн засгийн үйл ажиллагаанд өмчлөлийн харилцааг ашиглах гол чиглэл байна. Энэ үүднээс манай нөхцөлд ямар хэлбэрийн өмч байх ёстой, түүнийг тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэхэд хэрхэн ашиглах талаас өмчийн хэлбэрийг бүрдүүлэх, зөв тооцоог хангах, улмаар түүнийг ашиглах болно. **Өмчлөлийн харилцааны талаас өмч хувьчлалын асуудалд хандах нь онол арга зүйн хувьд зөв юм.** Өмчийн хэлбэрийг бүрдүүлэх, өөрчлөх асуудлыг тэдгээрийг юунд хэрхэн ашиглах талаас бодож шийдэх нь зөв хандлага мөн.

**Дөрөв. Монгол улсын өнөөгийн нөхцөлд төрийн өмчийн гүйцэтгэх үүрэг**

Манай өнөөгийн сэтгэлгээ болон зах зээлд шилжих шилжилтийг хэрэгжүүлэх арга хэмжээний төвд хувийн өмч шиг сайн зүйлгүй, харин төрийн өмч бол чухал бус гэсэн номлол тун их газар авлаа. Энэ талаар ч эрэгцүүлэн бодож шүүмжлэлтэй хандаж байгаа эрдэмтэд, мэргэжилтэн төрийн зүтгэлтэн ховор байдаг. Ер нь төрийн өмчийн ач холбогдлыг үгүйсгээд зогсохгүй, төрийн өмчид олон арга хэлбэрээр хүйтэн хөндий хандаж байгаа нь ч харамсалтай.

Тэгвэл Монголын өнөөгийн нөхцөлд төрийн өмч хэрэгтэй юу? үгүй юу? Хэрэгтэй бол яагаад, хэрэггүй бол яагаад гэсэн энгийн мэт боловч чухал асуудал тавигдана. Харамсалтай нь ийм асуудал тавьж, дэвшүүлж байгаа нь ч ховор!

Сүүлийн 10 жилд төрийн өмч буюу монгол улсын бүтээн бий болгосон үнэт баялаг их хэмжээгээр устгагдаж, үрэгдэж үгүй боллоо.

Төрийн өмч хувьчлалтай холбогдон төрийн өмчийн ач холбогдлын талаар тухайн улсад ширүүн маргаан онол, практикийн хүрээнд гардаг. Үүний үр дүнд асуудлыг зөв буюу нэлээд нааштай шийддэг. Манайд энэ байдал үндсэндээ үгүйлэгдэж байна. Төрийн өмчийг хувийн өмчид шилжүүлэх ёстой гэсэн ганц лозунгаар асуудал шийдэгдэж байна. Өмнөх нийгмийн балаг гэдгээр төрийн өмч чухал гэсэн үг дуугарсан хүнийг "эсэргүү" мэт үзэх ч төлөв байлаа шүү дээ. Нийт өмчийг хувийн болговол зорилт биелэж, бурханы орон бүтээх мэт үзэл бодол гаднын нөлөөгөөр ноёрхосоор байна. Энэ үзэл бодол хүчтэй байна.

Зах зээл хөгжсөн оронд төрийн гүйцэтгэх үүрэг 90-ээд оноос эхлэн их хэмжээгээр буурсан. Төр өөрийн ачааллаа багасгахаас сайн зүйл байхгүй. Үүнээс зөрж огтхон ч болохгүй гэж дээр доргүй ярьж бодож, төрийн өндөрлөгийн түвшинд түүнийг хэрэгжүүлэх гэж зүтгэж байна. Энэ зөв үү?!

Манай өнөөгийн нөхцөлд асуудалд ингэж хандаж болохгүй гэсэн сөрөг хариулт өгөх нь эрдэмтэний ёс зүй, улс орны эрх ашигтай нийлэх болно. Яагаад?

- Төрийн өмчийн үүрэг өнөөгийн нөхцөлд чухал байгааг дурьдах гол асуудлын хүрээнд батлая:
1. Манай улсын эдийн засгийн хөгжлийн түвшин тун доогуур, бүтэц ерөөсгөл, тулгуур бодит салбар нь нүүдлийн мал аж ахуй, эдийн засгийн цар хэмжээ бага,
  2. Хүн ам цөөн нутаг дэвсгэр их, хүн амын байршилт зохистой бус,
  3. Хувийн хэвшлийн аж ахуй дөнгөж үүсэх төдий бөгөөд эдийн засгийн хөгжил, нийгмийн

- амьдралд эерэг нөлөөлөх нөлөө сул, гол төлөв хувийн жижиг дунд аж ахуй байгаа нь эдийн засаг нийгмийн хөгжилд тэр бүр ач тусаа үзүүлэх хэмжээнд хүрээгүй байгаа,
4. Зах зээлийн харилцааны зарчим, механизм өөрийн голидролоор хэрэгжих эдийн засгийн үндэс суурь бүрдээгүй,
  5. Тусгаар тогтнол, аюулгүй байдал, нийгмийн нийтлэг хэрэгцээг хангах боломж хувийн хэвшилд бүрдээгүй,
  6. Өнөөгийн нөхцөлд төр нь өөрийн бодлогыг өөрийн эдийн засгийн доривтой бааз суурьгүйгээр хэрэгжүүлэх бололцоогүй.
  7. Гадаад нөхцөл байдал, тухайлбал эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэхэд төрийн эдийн засгийн үүрэг чухал хэвээр байгаа гэх мэт.

Эд бүгдээс үзэхэд манай өнөөгийн нөхцөлд зах зээл өндөр хөгжсөн орнуудтай төрийн үүрэг, төрийн өмчийн ач холбогдлыг адилтган үзэж огт болохгүй. Эдийн засгийн асуудлыг шийдэхэд төрийн өмч ямар үүрэг гүйцэтгэхийг тодорхойлох, байр суурийг илэрхийлэх явдал өнөөгийн гол асуудлын нэг болж байна.

Эдийн засагт төрийн гүйцэтгэх үүрэг ирээдүйд ихээхэн хэмжээгээр буурч, гол нь бодлого боловсруулагч, зохицуулагчийн үүрэг гүйцэтгэнэ гэдэг. Энэ нь манай өнөөгийн практикт хэр тохирохыг бас бодолцвол зохино.

Засгийн газар, төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээг зохих ёсоор үзүүлж, иргэд хэрэглэгчдийг хамгаалж, хувийн сектор дахь аж ахуйн нэгжүүд өөр хоорондоо эрх тэгш өрсөлдөх орчин нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй байна. Хувийн хэвшлийнхэн илүү шуурхай, үр ашигтай эрхлэж чадах аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд Засгийн газар оролцохгүй байхын дээр тэдэнд туслах дэмжих шаардлага байна.

Хувьчлалын дараа Засгийн газар нь хувьчилсан секторын талаар бодлого боловсруулж, төлөвлөх (шаардлагатай бол) дангаар ноёрхогч үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг зохицуулах болон Засгийн газрын үндсэн үүрэгт ажилтай холбоотой УУГ (улсын үйлдвэрийн газар) болон төрийн байгууллагуудын үйл ажиллагааг удирдан явуулах анхаарлаа нэмэгдүүлэх хэрэгцээ хэвээр байна.